



ЗАСГИЙН ГАЗРЫН ТОХИРУУЛАГЧ АГЕНТЛАГ  
БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН УЛСЫН ХОРООНЫ  
ДАРГЫН ТУШААЛ

2024 оны 09 сарын 01 өдөр

Дугаар 1/44

Улаанбаатар хот

Г 3х3 сагсан бөмбөгийн Үндэсний шигшээ  
багийн бүрэлдэхүүнийг батлах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3.1 дэх заалт, 8.4 дэх хэсэг, Биеийн тамир, спортын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.7, 11 дүгээр зүйлийн 11.3.7, 11.3.9, 18 дугаар зүйлийн 18.3, 18.4 дэх хэсэг, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2 дахь хэсэг, Монгол Улсын сайд, Олимп, нийтийн биеийн тамир, спортын Үндэсний хорооны даргын 2023 оны A/22 дугаар тушаалаар батлагдсан "Үндэсний шигшээ багийг бүрдүүлэх спортын төрлийг сонгох, санхүүжүүлэх журам"-ыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.3х3 сагсан бөмбөгийн Үндэсний шигшээ багийн бүрэлдэхүүний нэрсийг хавсралтаар баталсугай.

2. Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн хэрэгжилтийг ханганд тус хуулийн 8 дугаар зүйлд заагдсан нээлттэй мэдээллийг байгууллагын цахим хуудсанд байршуулан мэдээллийн ил тод байдлыг ханганд ажиллахыг Монголын 3х3 сагсан бөмбөгийн холбоонд үүрэг болгосугай.


3. Батлагдсан бүрэлдэхүүн, орон тооны дагуу цалин, нийгмийн даатгалын шимтгэлийг сар бүр Монголын 3х3 сагсан бөмбөгийн холбоонд шилжүүлэхийг Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн агентлагийн ерөнхий нягтлан бодогч (А.Өнөрцэцэг)-д зөвшөөрсүгэй.

4. Цалин, нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайлан, хувь хүний орлогын албан татварын тайланг улирал тутам хянаж, холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг ханганд ажиллахыг Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтэс (Д.Цэрэнболд)-т, холбооны саналыг үндэслэн бүрэлдэхүүн хөдөлгөөнд тухай бүр өөрчлөлт оруулахыг Үндэсний шигшээ багийн бодлогын хэрэгжилтийн хэлтэс (Э.Билэгт)-т тус тус үүрэг болгосугай.

5. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавин ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын хэлтэс (Н.Батсүх)-т даалгасугай.

ДАРГЫН ҮҮРГИЙГ ТУР  
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

О.БАТТУЛГА



147401133

Биеийн тамир, спортын улсын хорооны  
даргын 2024 оны 02 дугээр сарын 01-  
ний өдрийн 144 дугаар тушаалын  
хавсралт



ЗХЗ САГСАН БӨМБӨГИЙН ҮНДЭСНИЙ ШИГШЭЭ  
БАГИЙН 2024 ОНЫ БҮРЭЛДЭХҮҮН

№	Овог	Нэр	Албан тушаал
1	Баттулга	Тэлмэн	Хөдөлгөөн засалч
2	Энхбат	Дөлгөөн	Тамирчин
3	Даваасамбуу	Дэлгэрням	Тамирчин
4	Цогт	Отгонжаргал	Тамирчин
5	Онолбаатар	Энхбаатар	Тамирчин
6	Ариунболд	Ананд	Тамирчин
7	Чулуунбаатар	Ихбаяр	Тамирчин
8	Онолбаатар	Хулан	Тамирчин
9	Мөнхсайхан	Цэрэнлхам	Тамирчин
10	Бат-Эрдэнэ	Ариунцэцэг	Тамирчин
11	Батцоож	Болор-Эрдэнэ	Тамирчин
12	Цэнджав	Болорцэцэг	Тамирчин
13	Өлзийбат	Индра	Тамирчин

---оо---